



# АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ШУУРХАЙ ЗӨВЛӨГӨӨНӨӨС ӨГӨГДСӨН ҮҮРЭГ ДААЛГАВРЫН ХЭРЭГЖИЛТ



2024 оны 08 дугаар сарын 19-ний өдөр

ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ  
ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР



1. Шинээр хийгдэж буй авто замын засварын ажлын талаар газар дээрээс нь бодит мэдээллийг бэлтгэж иргэдэд танилцуулах ажлыг зохион байгуулах.

*Хугацаа: 2024 оны 08 дугаар сарын 16-ны өдрийн дотор*





## Биелэлт: ХЗА

2024 онд 50.0 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар хийгдэхээр авто замын засвар арчлалтын ажил эхэлсэн 12 байршилд аймгийн ЗДТГ-ын ХБТХОХ, авто замын улсын байцаагч, Хот байгуулалт барилга захиалагчийн алба, Газрын харилцаа барилга хот байгуулалтын газрын холбогдох мэргэжилтнүүдээс ярилцлага авч, 8 ажлын мэдээлэл бэлтгэн иргэдэд хүргээд байна.

*Хэрэгжилт: Хэрэгжиж байна*







## Биелэлт: ХББЗА

Аймгийн хэмжээнд хийгдэж байгаа шинэ авто зам, зогсоол, засварын ажлуудын мэдээллийг өдөр бүр тогтмол иргэдэд хүргэн ажиллаж байна. Өнгөрсөн долоо хоногийн хугацаанд зам засвартай холбоотой нийт 16 бичлэг, 6 зурган мэдээллийг бэлтгэн байгууллагын цахим хуудсаар дамжуулан иргэдэд танилцуулж байна.

*Хэрэгжилт: Хэрэгжиж байна*





2. Авто замын засварын ажилтай холбоотойгоор зам хаах, нээх хугацааг иргэдэд урьдчилж мэдээлж байх талаар холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтарч ажиллах

*Хугацаа: 2024 оны 08 дугаар сарын 16-ны өдрийн дотор*





## Биелэлт: ХЗА

2024 онд хийгдэж байгаа авто замын засвар арчлалтын ажлын хүрээнд авто замыг хэсэгчлэн хаах, нээх хугацааг аймгийн ЗДТГ-ын ХБТХОХ, Хэвлэл мэдээллийн алба, авто замын улсын байцаагч, Хот байгуулалт барилга захиалагчийн алба, Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар, Орхон аймгийн замын цагдаагийн тасагтай хамтран иргэдэд мэдээлэх ажлыг тухайн хугацаанд зохион байгуулан ажиллаж байна

*Хэрэгжилт: Хэрэгжиж байна*

НАЙРАМДАА - ДУУЖДА





3. Хайрга дайрганы асуудлыг сумын төсвийн тодотголд оруулах талаар судалж танилцуулах.

*Хугацаа: 2024 оны 08 дугаар сарын 16-ны өдрийн дотор*





## Биелэлт: Баян-Өндөр сумын ЗДТГ

“Сансарын эрин” ХХК удирдлагатай уулзалт хийн нийт 17 багийн 119 гудамжны 115.9 мян.м<sup>2</sup> талбайд шаардлагатай байгаа 262 хово хайргыг тус газраас худалдан авах гэрээ байгуулахаар болоод байна. Шаардлагатай төсвийг Баян-Өндөр сумын болзошгүй аваарын зардлаас шийдвэрлэхээр судалгаа хийж байна.

**Хэрэгжилт: Хэрэгжиж байна**







4. Өргөх машин, механизмын улсын байцаагчийн асуудлыг яаралтай шийдвэрлэх талаар холбогдох яам, газруудад албан тоот өгч хамтарч ажиллах.

*Хугацаа: 2024 оны 08 дугаар сарын 16-ны өдрийн дотор*






## Биелэлт: ГХБХБГ

Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдад Өргөх машин, механизмын улсын байцаагчийн орон тооны асуудлыг шийдвэрлэж өгөх талаар аймгийн Засаг даргын 01/2313 дугаарт албан бичгийг 2024 оны 08 дугаар сарын 16-ны өдөр хүргүүлсэн.

**Хэрэгжилт: Хэрэгжих шатандаа**





5. ЗТХЯ-нд Орхон АЗЗА ТӨХК-ийн техник, хүн хүч дутагдалтай байгаа талаар болон цаашид Хойд бүсийн аймгуудын АЗЗА ТӨХК-иуд хамтран ажиллах талаар санал гаргах, хүсэлт хүргүүлэх

*Хугацаа: 2024 оны 08 дугаар сарын 16-ны өдрийн дотор*







## Биелэлт: ХБТХОХ

ЗТХЯ-нд Орхон АЗЗА ТӨХК-ийн техник, хүн хүч дутагдалтайгаас үүдэн хот хоорондын зам засвар удаашралтай байгаа талаар, зам засварын ажлын Хойд бүсийн аймгуудын АЗЗА ТӨХК-иуд хамтран ажиллах санал бүхий албан бичгийн төслийг боловсруулсан.

**Хэрэгжилт: Хэрэгжих шатандаа**





6. Элсэлтийн Ерөнхий шалгалтад өндөр оноо /800 оноо/  
авсан сурагчдыг урамшуулах ажлыг зохион байгуулах.

*Хугацаа: 2024 оны 08 дугаар сарын 16-ны өдрийн дотор*





## Биелэлт: Боловсролын газар

Элсэлтийн ерөнхий шалгалтын дүнгээр хамгийн өндөр оноо буюу 800 оноо авсан 10 сурагч тус бүрийг 1.0 сая төгрөгөөр шагнаж урамшуулах ажлыг 2024 оны 08 дугаар сарын 13-ны өдөр зохион байгуулж батламжийг гардуулсан.

**Хэрэгжилт: Хэрэгжсэн**







7. Хот тохижуулах газарт нийлүүлэгдэх тусгай зориулалтын техник хэрэгслүүдийг хүлээн авч, гэр хорооллын /Дэнж багаас эхлэх/ авто замын засварын ажилд оролцуулах ажлыг зохион байгуулах, Баян-Өндөр сум багуудын эвдрэлтэй, засвар хийлгэх шаардлагатай гудамжуудыг гаргаж өгөх.

*Хугацаа: 2024 оны 08 дугаар сарын 16-ны өдрийн дотор*





## Биелэлт: ХТГ

Тус байгууллагад ирэх автозамын засварт шаардлагатай 4 автомашин, механизмуудаас далангийн индүү, 50 ковш, тусгай тоноглолтой автомашинууд ирсэн бөгөөд автогрейдр ирээгүй байна. Гэр хорооллын багуудын засварлах шаардлагатай сайжруулсан шороон автозамуудын судалгааг гаргаж байна.

**Хэрэгжилт: Хэрэгжиж байна**

НАЙРАМДАА - ДУУЖДА



# АНХААРАЛ ХАНДУУЛСАНД БАЯРЛАЛАА

2024 он

НАЙРАМДАА - ДРЧУЖДА

